



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/393

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бамбар төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан тул Бамбар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сургалтын хугацаатай уялдуулан 5 жилээр сунгасугай.

2.Сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн явуулж, сургуулийн өмнөх боловсролын стандартыг чанартай хэрэгжүүлж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгчид даалгасугай.

3.Цэцэрлэгийн цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтарч ажиллахыг сумын Засаг даргад, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг), хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч (Б.Огтонцолмон)-д тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ



• 231010873